



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ГАЗАР ИВЭЭЛ” ТӨААТҮГ-ЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/98/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Хосжаргал
Утас: 261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Энхжин
Утас: 260512 Цахим хаяг: enkhjinb@audit.gov.mn
Гэрээгээр гүйцэтгэсэн “Акпар-Аудит” ХХК-ийн
Захирал Х.Баянбай
Утас: 11462131 Цахим хаяг: akpar.audit@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
3. Аудитын тайлан.....	7
3.1 Ерөнхий зүйл.....	7
3.2 Дотоод хяналт.....	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	7
3.4 Материаллаг байдал	7
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	8
4.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	8
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	8
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	9
4.4. Үйлдвэрлэл, борлуулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл	10
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	10
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	10
5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	10
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	11
7. Аудитын илрүүлэлт	11
7.1 Залруулсан алдаа	11
7.2 Зөвлөмж.....	11
8. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УЗ	Удирдах зөвлөл
ШШГЕГ	Шүүхийн шийдвэрийн ерөнхий газар



ГАЗАР ИВЭЭЛ ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ,
ХУРАНДАА Б.ЮМЧИНБАГАНА ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.03.15 № 07/595
танай _____-ны № _____-т

Хараат бус аудиторын тайлан

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Газар ивээл ТӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Газар ивээл ТӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2020 оны 12 сарын 30-ны А/211 дугаар тушаалаар 2021 оны нийт орлогыг 790.5 сая төгрөгөөр, дээд шатны байгууллагад төвлөрүүлэх дотоод орлогыг 115.0 сая төгрөг байхаар баталж, зардал болон ашгийг батлаагүй байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 19 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэл 96 хувьтай гэж тайлагнасан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	159,656,201.70	171,769,455.74
1.1.2	Дансны авлага	18,000,000.00	8,986,500.00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	50,409.09	-
1.1.4	Бусад авлага	-	-
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	45,656,033.00	65,414,961.37
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	-
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
	Эргэлтийн хөрөнгийн дүн	223,362,643.79	246,170,917.11
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	182,330,880.96	194,028,861.71
1.2.2	Биет бус хөрөнгө	239,743.68	724,536.83
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.5	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	182,570,624.64	194,753,398.54
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	405,933,268.43	440,924,315.65
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	-	-
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-
2.1.1.3	Татварын өр	1,193,987.85	3,647,665.41
2.1.1.4	НДШ–ийн өглөг	-	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.6	Хүүний өглөг	-	-
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	-	-
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	-
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,193,987.85	3,647,665.41
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	-	-
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,193,987.85	3,647,665.41
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:- төрийн	209,570,029.00	209,570,029.00
2.3.2	- хувийн	-	-
2.3.3	- хувьцаат	-	-
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	1,934,810.33	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг	193,234,441.25	227,706,621.24
2.3.10	Эздийн өмчийн дүн	404,739,280.58	437,276,650.24
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	405,933,268.43	440,924,315.65

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	862,787,272.75	829,574,536.44
2	Борлуулалтын өртөг	635,456,740.15	640,504,863.94
3	Нийт ашиг(алдагдал)	227,330,532.60	189,069,672.50
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	610,530.48	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	-	-
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	96,289,280.01	81,423,032.24
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	-	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	(92,658,600.00)	(63,383,553.50)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	38,993,183.07	44,263,086.76
19	Орлогын татварын зардал	14,358,265.25	11,725,717.10
20	Татварын дараах ашиг (алдагдал)	24,634,917.82	32,537,369.66
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	24,634,917.82	32,537,369.66

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	/төгрөгөөр/		
		Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	209,570,029.00	1,934,810.33	168,599,523.43	380,104,362.76
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)	-	-	-	-
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	24,634,917.82	24,634,917.82
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	209,570,029.00	1,934,810.33	193,234,441.25	404,739,280.58
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	(1,934,810.33)	1,934,810.33	-
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	32,537,369.66	32,537,369.66

Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	209,570,029.00	0.00	227,706,621.24	437,276,650.24

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<i>/төгрөгөөр/</i>		
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	929,886,000.00	918,505,490.00
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	929,886,000.00	918,505,490.00
Бусад мөнгөн орлого	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	799,686,542.60	796,242,235.96
Ажиллагчдад төлсөн	186,884,456.53	198,993,577.36
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,350,113.38	2,248,499.36
Бараа материал худалдан авахад төлсөн	515,782,359.00	503,753,105.00
Ашиглалтын зардалд төлсөн	648,000.00	1,933,600.00
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	5,352,300.00	8,119,250.00
Хүүнийн төлбөрт төлсөн	-	-
Татварын байгууллагад төлсөн	63,807,877.69	62,036,407.18
Даатгалын төлбөрт төлсөн	187,100.00	187,110.00
Бусад мөнгөн зарлага	24,674,336.00	18,970,687.06
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	130,199,457.40	122,263,254.04
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	9,849,880.48	9,260,000.00
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	9,239,350.00	9,260,000.00
Хүлээн авсан хүүний орлого	610,530.48	-
Мөнгөн зарлагын дүн (-)	10,339,350.00	13,410,000.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,100,000.00	4,150,000.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	9,239,350.00	9,260,000.00
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(489,469.52)	(4,150,000.00)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	8,000,000.00	9,000,000.00
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
Бусад	8,000,000.00	9,000,000.00
Мөнгөн зарлагын дүн (-)	105,000,000.00	115,000,000.00
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
Бусад	105,000,000.00	115,000,000.00
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(97,000,000.00)	(106,000,000.00)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	32,709,987.88	12,113,254.04
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	126,946,213.82	159,656,201.70
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	159,656,201.70	171,769,455.74

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Газар ивээл ТӨААТҮГ -ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад орлогын албан татвар, үндэсний мөнгөн тэмдэгтээр гэрээ хэлцлийг хийх өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 10-наас 2022 оны 03 дугаар сарын 12-ны хооронд Акпар-Аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Эрдэнэсүрэн, аудиторын туслах Э.Оюударь нар гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал Х.Баянбай хэрэгжүүлсэн.

Газар ивээл ТӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 3/13 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Газар ивээл ТӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 746.1 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 14.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаад, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Газар ивээл ТӨААТҮГ-ын зорилгыг “ШШГЕГ-ын хорих ангид ял эдэлж байгаа хоригдлуудыг тус үйлдвэрт ажиллуулснаар улсад болон иргэнд учруулсан гэм хорыг ажлын хөлсөөр нь барагдуулах болон арьсан эдлэл хийх арга барилд сургаж, хоригдох хугацаанд нь хөдөлмөр эрхлүүлэн нийгэмшүүлэхэд оршино” гэж тодорхойлжээ.

Үйлдвэрийн газрын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ерөнхий газраас баталсан төлөвлөгөөний дагуу гутал, арьсан эдлэл үйлдвэрлэж хорих анги, хоригдогсдын хэрэгцээнд нийлүүлэх;
- Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа хуулийн этгээдийн дүрэмт хувцасны гутал, ажлын гутал, тэлээ, бүс, бусад арьсан эдлэл үйлдвэрлэн нийлүүлэх;
- Байгууллагын албан хаагч, ажиллагсад, бусад захиалагчийн хэрэгцээнд чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг худалдан борлуулах;
- Техник, технологийн дэвшил нэвтрүүлэх, тоног төхөөрөмж туршин нэвтрүүлэх, зохион бүтээх, шинэ бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх;
- Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гадаад, дотоодын байгууллагатай хамтран ажиллах, туршлага солилцох;
- Хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад үйл ажиллагаа

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд ТӨААТҮГ гэсэн статустай байгаа ба өмчийг 100.0 хувь төр буюу Хууль зүй, дотоод хэргийн яам эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Газар ивээл ТӨААТҮГ нь ШШГЕГ-ын даргын 2017 оны А/256 дугаар тушаалыг үндэслэн байгуулагдсан байна. Энэ нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 259 дүгээр зүйлийн 259.4-д “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага харьяандаа сургалт, судалгаа, шинжилгээ явуулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих шуурхай удирдлагын нэгж болон үйлдвэрлэл, үйлчилгээ, санхүү, хангалт, архив, урлаг, спорт хариуцсан нэгжтэй байна” гэсэн заалттай нийцэж байна.

Үйлдвэрийн газрын дүрмийн 7 дугаар бүлгийн 7.1-д “ Үйлдвэрийн газрын эрх барих байгууллага нь Ерөнхий газрын даргын тушаалаар байгуулагдсан удирдах зөвлөл байна”, 7.2-д “Удирдах зөвлөлд Ерөнхий газрын санхүү, төсвийн асуудал хариуцсан газрын дарга, санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, үйлдвэрлэл хариуцсан ахлах мэргэжилтэн, төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын төлөөлөл, үйлдвэрийн газрын захирал тус тус багтана”, 7.6-д “Удирдах зөвлөл 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байх ...” гэж заасны дагуу удирдах зөвлөл 7 гишүүнтэй байгуулагдсан боловч дүрмийн дагуу ажиллахгүй байгаа нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 259 дүгээр зүйлийн 259.4, 262 дугаар зүйлийн 262.1.9 заалттай нийцээгүй, ШШГЕГ-ын даргын зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 21 дүгээр хуралдааны шийдвэр хэрэгжихгүй үр дагавартай байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-д заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас “Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх тухай” 2021 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 06/502 тоот албан бичгийн дагуу хэмнэлтийн горимд шилжин ажилласан байна. ШШГЕГ-ын 2020 оны 12 сарын 30-ны өдрийн А/211 тоот тушаалаар 8 орон тоо баталснаас 2021 онд 7 орон тоотой ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Газар ивээл ТӨААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	159,656.2	171,769.5	12,113.3
Авлага	18,050.4	8,986.5	(9,063.9)
Бараа материал	45,656.0	65,415.0	19,759.0
Үндсэн хөрөнгө	182,330.9	194,028.9	11,698.0
Биет бус хөрөнгө	239.7	724.5	484.8
Нийт хөрөнгийн дүн	405,933.2	440,924.4	34,991.2
Өр төлбөрийн дүн	1,193.9	3,647.7	2,453.8
Богино хугацаат өглөг	1,193.9	3,647.7	2,453.8
Урт хугацаат өглөг	-	-	-
Эздийн өмч	404,739.3	437,276.7	32,537.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	405,933.2	440,924.4	34,991.2

Банк дахь харилцах дансанд байгаа 171.8 сая төгрөг байна.

Тайлант онд харилцагчдаас авах авлага 9.1 сая төгрөгөөр барагдсан нь авлагын бууралтад нөлөөлжээ. Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа бусад авлага 9.0 сая төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 65.4 сая төгрөг болж 19.8 сая төгрөгөөр өссөн нь хил хаагдсанаас түүхий эд материалын татан авалт төлөвлөсөн хугацаанаас хийгдэж, оны эцэст түүхий эд материалын нөөц үүссэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө худалдан авсан 4.2 сая, ТӨБЗГ-ын 2021 оны 15, 701 дүгээр тогтоолоор үнэ шинэчлэн тогтоосон 41.3 сая төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2021 оны 15, 576, 701 дүгээр тогтоолоор акталсан 81.2 сая төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгө шинэчлэн тогтоосон үнэ 1.0 төгрөгийн хөрөнгөөр нэмэгджээ.

Богино хугацаат өр төлбөр 2.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны аж ахуйн нэгжийн орлогын татварын өглөг байна.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт ирээдүйд байгууллагад эдийн засгийн үр ашиг, өгөөж бий болох боломжтой буюу магадлалтай байх, зардлын дүн эсвэл өртгийн найдвартай, үнэн зөв хэмжих боломжтой байх шалгуурыг хангасан нөхцөлд зардлыг хүлээн зөвшөөрөхөөр тусгасан байна. Мөн орлого, зардал зохицох зарчмын дагуу гарсан зардал болон өртгийг түүнтэй холбоотой олсон орлогод шууд хамааруулах үндсэн дээр хүлээн зөвшөөрнө. Энэ зарчмын дагуу ажил гүйлгээ болон бусад үйл явдлын үр дүнд шууд бий болсон орлого, зардлыг нэгэн зэрэг хамтад нь хүлээн зөвшөөрөхийг шаарддаг тул үйлчилгээний өртгийг түүнтэй холбоотой орох орлогод нь шууд хамааруулан орлого, зардлыг уялдуулан хүлээн зөвшөөрнө гэж заажээ.

Үйл ажиллагааны зардлыг тайлант хугацааны туршид аккруэл суурьт үндэслэн холбогдох зардлын данснуудад хуримтлуулан бүртгэх ба аккруэл суурьт бүртгэлийн дагуу ажил гүйлгээ гарсан бөгөөд мөнгөн дүнг нь хэмжиж тодорхойлох боломжтой болсон үед төлбөр төлөгдсөн эсэхээс үл хамааран гарсан зардлаас тайлант хугацаанд хамаарах хэсгийг хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна.

Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөгт түүхий эд материал, хоригдол, ялтны ажлын хөлс, сэлбэг хэрэгсэл, урсгал засвар, түрээсийн зардлуудыг хамруулсан байна.

4.4. Үйлдвэрлэл, борлуулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Газар ивээл ТӨААТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

ШШГЕГ-ын 2020 оны 12 сарын 30-ны А/211 дугаар тушаалаар Газар ивээл ТӨААТҮГ-ын 2021 оны үйлдвэрлэл, борлуулалтын төлөвлөгөөнд нийт орлогыг 790.5 сая төгрөгөөр, дээд шатны байгууллагад төвлөрүүлэх дотоод орлогыг 115.0 сая төгрөг байхаар баталсан байна. ШШГЕГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын газраас үйлдвэрлэл, борлуулалтын төлөвлөгөөг батлахдаа зөвхөн бүтээгдэхүүний тоо хэмжээнд суурилан үйлдвэрлэлт, борлуулалтын орлогыг тооцоолдог бөгөөд зардал болон ашгийг тооцоолоогүй байна.

Гүйцэтгэлээр 881.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөснөөс 90.7 сая төгрөг буюу 11.5 хувиар өссөн нь захиалгат ажлууд нэмэгдсэнээс шалтгаалсан байна. Дээд шатны байгууллагад 115.0 сая төгрөгийг бүрэн төвлөрүүлжээ.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Газар ивээл ТӨААТҮГ нь тайлант онд нийт 3,307.7 сая төгрөгийн ажил, гүйлгээний 147 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь байршуулсан байна.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Тус газрын захирлын баталсан 2021 оны А/07, А/10 тоот тушаалууд бэлтгэн нийлүүлэгч БНХАУ-ын иргэнтэй байгуулсан гэрээнд мөнгөн дүнг юаниар илэрхийлсэн нь Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр хийх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 “Бараа, ажил, үйлчилгээний үнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлж, түүгээр төлбөр тооцоог гүйцэтгэх ба энэ хуулийн 4.4-т зааснаас бусад тохиолдолд Монголбанкны албан ёсны зөвшөөрөлгүйгээр гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх, зарлан сурталчлахыг хориглоно”, 4.3 “Монгол Улсын хууль тогтоомжид хураамж, шимтгэл, хариуцлагын хэмжээг тодорхойлохдоо зөвхөн төгрөгөөр илэрхийлнэ” заалттай нийцээгүй, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээ хэлцэлд мөнгөн дүнг тусгахдаа үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлж байх зөвлөмж өгөх

2. “Газар ивээл” ТӨААТҮГ-ын үйлдвэрлэлт, борлуулалт, орлогын төлөвлөгөө нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3-т “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” заалттай нийцэхгүй, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ТӨААТҮГ-ын зорилтот түвшний төлөвлөгөөтэй ижил загвараар батлуулах зөвлөмж өгөх

3. Үйлдвэрийн газрын дүрмээр удирдах зөвлөл 7 гишүүнтэй байгуулагдсан боловч нэг ч удаа хуралдаагүй байгаа нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 259 дүгээр зүйлийн 259.4, 262 дугаар зүйлийн 262.1.9 заалттай нийцэхгүй, ШШГЕГ-ын даргын зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 21 дүгээр хуралдааны шийдвэр хэрэгжихгүй, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Удирдах зөвлөлийг хууль, дүрмийн дагуу ажиллуулах талаар зөвлөмж өгөх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, гэрээ хэлцлийг байгуулахдаа мөнгөн дүнг үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлээгүй нь Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр хийх тухай хууль, батлуулсан төлөвлөгөө нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, удирдах зөвлөл ажиллахгүй байгаа нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хүрээнд шалгасан зүйлийн холбогдох шалгуурт тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 19.8 сая төгрөгийн 1 алдаа илрүүлж, 2 зөвлөмж өгснийг аудитын явцад 1 алдааг залруулсан, 1 зөвлөмж нь арилгах боломжгүй байгаа тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

7. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 19.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 19.8 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 0.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

Залруулагдаагүй 0.1 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 14.9 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

7.1 Залруулсан алдаа

СТОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга стандарттай нийцээгүй, “Ангилал болон ойлгомжтой байх” батламж мэдэгдлийг хангаагүй санхүүгийн тайланд бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн урьдчилгаа төлбөрийг дансны авлагаар бүртгэсэн 19.8 сая төгрөгийн алдааг аудитын явцад залрууллаа.

7.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Орлогын татварын зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус газрын санхүүгийн тайланд тусгагдсан 0.06 сая төгрөгийн орлогын татварын зардал нь ААНОАТ-ын тайлан дахь дүнгээс зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7 "аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах" гэсэн заалттай нийцэхгүй, “Толилуулга ба тодруулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Оны эцэст татварын байгууллагатай тооцоо нийлж, зөрүүг арилгах. Цаашид улирал, жилийн тайлан гаргахаас өмнө татварын систем дэх өрийн үлдэгдлийг тулган шалгадаг байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

8. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Газар ивээл ТӨААТҮГ	САГ-2022/98/СТА-ТӨҮГ	Тус газрын санхүүгийн тайланд тусгагдсан орлогын татварын зардал нь ААНОАТ-ын тайлан дахь дүнгээс зөрүүтэй байна.	Орлогын татварын зардлыг татварын хуулийн дагуу үнэн зөв тооцон, нягтлан бодох бүртгэлдээ тусгах	1	61.0									1	61.0
ДҮН					1	61.0									1	61.0
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																
1	Газар ивээл ТӨААТҮГ	САГ-2022/98/СТА-ТӨҮГ	Тус газрын захирлын баталсан 2021 оны А/07, А/10 тоот тушаалуудад бэлтгэн нийлүүлэгч БНХАУ-ын иргэнтэй байгуулах гэрээний төсөвт өртгийг юаниар баталсан бөгөөд гэрээг юаниар байгуулсан.	Захирлын тушаал шийдвэр гаргах болон гэрээг байгуулахдаа Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр хийх тухай хуулийн заалтыг баримталж ажиллах.	1	-									1	-
2	Газар ивээл ТӨААТҮГ	САГ-2022/98/СТА-ТӨҮГ	Тус газрын үйлдвэрлэлт, борлуулалт, орлогын төлөвлөгөө нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3-т “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохиц байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” заалттай нийцэхгүй	ТӨААТҮГ-ын жишиг загварыг ашиглан зорилтот түвшний төлөвлөгөөнд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээнээс гадна борлуулалтын болон бусад орлого, өртөг, зардал, ашиг, ноогдол ашгийг тусган батлуулж байх.	1	-									1	-
ДҮН					2	-									2	-
НИЙТ ДҮН					3	61.0									3	61.0

